

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

- Хүнс хөдөө аж аухуй Хөнгөн үйлдвэрийн сайдын А/02 тушаал, мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/05 тушаал, Сумын Засаг даргын 2023 оны 03дугаар сарын 21-ны өдрийн А/44 тоот захирамжуудыг үндэслэн Гоц халдварт Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулан ажилласан.
- Гоц халдварт Хонины цэцэг өвчин нь 05 дугаар сарын 03-ны өдөр 23-3339 тоот шинжилгээний дүнгээр батлагдсан учир сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/84 Хорио цээрийн дэглэмийг 30 хоногийн хугацаатай тогтоон ажиллаж байна.
- Сумын засаг даргын 2023 оны 05 сарын 12-ны өдрийн А/94 тоот захиармжаар бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж 7 байгууллагын 18 ААН 1210 иргэний хамарсан 25 га газрыг 30тн хог хаягдал устгаж цэвэрлэсэн байна.
- Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны мод тарилтыг 05 сарын 15-ны өдрөөс зохион байгуулж ХХҮГазарт төсөл бичин дэмжигдэж түр ажлын байраар 20 иргэнийг хамруулж ажиллав. Модны нэр төрөл: Улиас 400ш, хайлаас, 4400, буйлс 100 ширхэг тарьж усалгаа, арчилгаа тордолгоо, таналт хийв.

ЕБС: "БАГШИЙН БОЛОН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН

ҮНЭЛГЭЭ-2023" сургалт зохион байгуулж, Сургалтын байгууллага, Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 2023.05.15-19-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. **Аймгийн ИТХ-ын 02 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил хамгаалалыг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд:** “Багш эргүүл” Өдөр бүр 19:00-24:00 хооронд 2 багш эргүүл багшийн үүрэг гүйцэтгэнэ. Одоогийн байдлаар 54 багш 2 удаагийн эргүүлээр нийт 108 удаагийн эргүүл хийгдээд байна.

"ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР"-т зориулан Ханс Андерсены үлгэрүүд болон дэлхийн сонгодог зохиолуудыг уншиж судлан “ТОМ НОМ”, “БЯЦХАН НОМ”, “ХАНЫН СОНИН” бүтээх уралдааныг 1-12 дугаар ангийн сурагчдын дунд 10 хоногийн хугацаатай зохион байгууллаа. "ЖААХАН ШАРГЫН НУТАГ " Монгол бичгийн уралдааны Уран бичлэгийн төрөлд ТЭРГҮҮН байр, ТАТАЛГАН бичгийн төрөлд МХУЗ багш М.Мөнхнаран , Уран бичлэгийн төрөлд 10в ангийн сурагч (М.Мөнхнаран багшийн шавь) Г.Нарансолонго Гутгаар байр тус тус эзэлсэн. “Эрдэмд хөтлөх

бидний баяр тайланд өдөрлөг” 2022 - 2023 оны хичээлийн жилд 1-р ангид суралцсан сурагчид маань бүтэн жилийн турш эрдмийн их гарааныхаа суурийг тавьж, хичээнгүйлэн сурсан эрдэм мэдлэгээ сургуулийн удирдлага, эрдэмтэн багш, эцэг эх, асран хамгаалагчдадаа тайлагнаж “Үсэглэлийн баяр”-аа баяр хөөр дүүрэн тэмдэглэлээ.

Санхүүгийн чиглэлээр:

2023 оны ААНэгж байгууллагын сангийн яамны тайлан тушаах ажлыг зохион байгуулан жагсаалт гарган мэдээлэл хүргүүлэн ажилласан.

2023 оны 5-р сарын орлогыг хааж төвлөрүүлсэн.

1. Цалин, хөлс түүнтэй адилтгах орлого -255,639,033.05
2. Үйл ажиллагааны орлого – 1,014,792.66
3. Хөрөнгийн орлого -18,995,439.10
4. Шууд бус орлого – 77,055,820.14
5. Малын тоо толгойд огдуулах албан татвар – 34,372,500
6. Бууны албан татвар – 564,000
7. ҮХХАТ- 9,354,807.84
8. Байгалын ургамлын нөөц ашигласны албан татвар – 2,023,900
9. Улсын тэмдэгтийн хураамж- 1,117,800
10. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр – 372,000
11. Газрын төлбөр- 43,700,818
12. Торгуулийн орлого – 19,369,000 нийт 12 нэр төрлийн 463,579,910.8

төгрөгийн орлого төвлөрүүлэн хаалтыг хугацаанд хийж орлогыг 40%-ийн биелэлттэй төвлөрүүлэн ажиллаа. Аймгийн санхүүгийн дэмжлэг хувиараар 222,807,300 төгрөгийн санхүүжилт ирсэнээс орон нутгийн 3 байгууллага, ТЗШ-ын 5-н байгууллагад 591,691,400 төгрөгийн санхүүжилтийг олгож, 2023 оны 5-р сард 729 ширхэг гүйлгээг хянаж батлан 4,759,370,275 төгрөгийн гүйлгээ хийгээд байна.

➤ **Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:**

- “Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаа.

Е-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд:

Д/д	Үйлчилгээний тоо			Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
1	5		12	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	12
2			3	Иргэний үнэмлэхийн лавлагаа	3
3			2	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	2
4			1	Жолоочийн лавлагаа, мэдээлэл	1
5			1	Хилийн цэргийн төв архив - Хугацаат цэргийн алба хаасан тухай лавлагаа	1
Нийт		0	19		19

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын хэмжээнд төл малын мэдээ 145906 толгой эх мал төллөж 71,1 хувьтай байна.төлийн хорогдол-720 д хүрсэн байна. Том малын хорогдлын мэдээ адуу-86, үхэр-57, хонь-474, ямаа-629 нийт 1246 толгой мал хорогдсон байна. Багаас ирж байгаа мэдээ хангалтгүй ирж, өрх бүр бүрэн хамрагдаж ирэхгүй байгаатай холбоотойгоор дээд байгууллагаас удаа дараа сануулсан байна.

Малын шилжилт бүртгэлийн шинэчилсэн программыг 8 багийн Засаг дарга нартай хамтран шинээр суулгаж ажилдаа нэвтрүүлэн ашиглаж эхэллээ.

5-р сард тариалалт эхэлсэн. Үр тарианы аж ахуйн нэгж тариалалтын ажлаа эхлүүлэн хөрсөө боловсруулж байна. Иргэн аж ахуйн нэгжүүдээс Төмс 5 га тариалсан мэдээ ирсэн.

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 1,4,7,8-р багуудад 1500 га талбайд мал амьтанд сөрөг нөлөөгүй огтоны хорыг цацаж үлийн цагаан огтоны устгалыг хийж ажилласан. Энэхүү ажилд 28 иргэн, 2 тээврийн хэрэгсэл оролцож 10 л А-92 шатахуун зарцуулсан

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.